



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Отгоншарын БАТНАЙРАМДАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-34-84, Факс: 32-70-16
E-mail: batnairamdal@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.27 № 4122 03/8060
танай _____-ны № _____-т

Хянан шалгах түр хороо байгуулах
хүсэлт гаргах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн, Оюутолгойн бүлэг ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлж, Монгол Улсын эрх ашгийг хангах зорилгоор дараах асуудлын хүрээнд хянан шалгах түр хороог байгуулах шаардлагатай байна. Үүнд:

Оюу толгой стратегийн ач холбогдол бүхий бүлэг ордын хил заагт Канад Улсын хөрөнгө оруулалттай Онтрэ ХХК-ийн эзэмшилд буй “Шивээ Толгой” болон “Жавхлант” ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хамаарч байна. Уг хоёр тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах газрын хэвлийн баялгийг ашиглахад Монгол Улсын эрх ашгийг хангахтай холбоотой гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй ирсэн байна. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 6.2 дахь заалтад нийцүүлэн, Ашигт малтмалын тухай хуулийн 5.5, 8.1.7, 9.1.5 дахь заалтад тусгасны дагуу тус ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг Улсын Их Хурлаар яаралтай шийдвэрлүүлэх;

Хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-нд хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн нөхцөл 3 сарын SOFR дээр нэмэх 6.5 хувь (SOFR+6.5%) мөн бусад зээлийн зардал нэмэгдэн, өнөөдрийн байдлаар ойролцоогоор жилийн 11.1 хувь байна. Уг санхүүжилтийн зардал нь сүүлийн жилүүд дэх Монгол Улсын төр болон хувийн хэвшлийн зээлдэгчдийн олон улсын ам.долларын санхүүжилттэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна. Оюу толгой ХХК-ийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж, Монгол Улсын ногдол ашиг авах хугацааг хойшлоход бодитоор нөлөөлж буй энэхүү зээлийн хүүгийн зохистой түвшинг тус гэрээний 11.3(ё)-д зааснаар долоон жил тутамд авч хэлэлцэх боломжтой бөгөөд энэхүү хугацаа нь 2025 оны эцэст дуусгавар болохоос өмнө яаралтай хэлэлцэн бууруулах.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 8.. хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.БАТНАЙРАМДАЛ

2025000069



Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Ө.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

2025000069

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГ

Ж.ГАЛБАДРАХ

Г.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

А.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

М.ГАНХҮЛЭГ

Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

2025000069

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Б.ТУЛГА

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Д.ҮҮРИЙНТУЯА

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Б.Хосбаяр
Д.Цогтбаатар
О.Цогтгэрэл
С.Цэнгүүн

Г.УЯНГАХИШИГ

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.Чойжилсүрэн

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.Энхбаяр

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТҮВШИН

Д.ЭНХТУЯА

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНБҮРЭН

Р.Эрдэнбүрэн

2025000069

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.БАТНАЙРАМДАЛ

**“ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ
ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ”-ТЭЙ ХОЛБООТОЙ
БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ХЯНАН
ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна.” гэж тус тус заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Оюутолгой бүлэг ордыг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан байдаг. Иймд Оюутолгой төслийн асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь энэхүү асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

1.2.Практик шаардлага

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Оюутолгой бүлэг ордыг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан байдаг.

Улмаар Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 170 дугаар тогтоолоор Оюутолгойн бүлэг ордын талбайн хил заагийг тогтоосон. Ийнхүү Оюутолгой бүлэг ордын талбайн хил заагийг тогтоосноор Канад Улсын

хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, тус улсад бүртгэлтэй “Онтрэ ресурс лимитэд” компанийн шууд хөрөнгө оруулалттай, түүний охин компани болох Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад бүртгэлтэй “Онтрэ” ХХК-ийн эзэмшиж буй “Жавхлант” (MV-15225), “Шивээ толгой” (MV-15226) ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

“Жавхлант”, “Шивээ толгой”-н ашигт малтмалыг ашиглах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх...” гэж заасан шаардлагыг хангуулах, түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7-д зааснаар “ ... стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших ...” эсхүл түүнийг “ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэж заасан боломжит хувилбаруудаас бүрэн эрхийнхээ хүрээнд хугацаа алдахгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байна.

“Жавхлант”, “Шивээ толгой” стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улс төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохдоо хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын оролцоо, хяналттайгаар, түүнд олон нийтийн санал, хүсэлтийг ил тод, нээлттэй тусган тогтоох замаар “өмнөх алдаа давтагдах”-аас зайлсхийх нь чухал бөгөөд “Оюутолгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлд “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 13.1-д заасны дагуу “Оюутолгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчид болон түүний хамаарал бүхий компаниас авсан зээлийг ойлгох бөгөөд 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Рио Тинто болон түүний хамаарал бүхий компаниас авсан зээлийн нийт үлдэгдэл 11.8 тэрбум ам.доллар (үндсэн зээл: 6.1 тэрбум ам.доллар, хуримтлагдсан хүү: 5.7 тэрбум ам.доллар) байна.

Уг зээлийн хүү нь 3 сарын SOFR дээр нэмэх 6.5 хувь (SOFR+6.5%), бусад зээлийн зардал нэмэгдэн, өнөөдрийн байдлаар ойролцоогоор жилийн 11.1 хувийн хүүтэй байна. Үүнээс үзэхэд Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн үлдэгдэл үндсэн зээлийн үлдэгдлийн 94 хувьтай тэнцүү байх төлөвтэй байна. Нийлмэл хүүгийн нөлөөгөөр хүүгийн зардал жилээс жилд тасралтгүй өсөх төсөөлөлтэй ба 2028-2037 онд зээлийн хүүд 18.0 тэрбум ам.доллар буюу үндсэн зээлээс 2.8 дахин их хэмжээний хүү төлөхөөр байна.

Түүнчлэн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг Оюутолгойн гуравдагч этгээдээс авсан зээлүүд болох төслийн санхүүжилтийн зээлийн хүүтэй харьцуулахад 1.78-3.5 хувиар өндөр байна.

“Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 11.3(ё)-д 7 жил тутам Санхүүжилтийн хүүгийн хувийн зохистой байдлыг хянан үзэх бөгөөд эдгээр хувийг бүх Тал зөвшөөрснөөр өөрчилж болно гэж заасан байдаг. Үүний дагуу хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулахад Монгол Улсын Оюутолгой төслөөс хүртэх өгөөж богино хугацаанд бодитоор өсөх боломжтой.

Оюутолгой төслийн санхүүжилтийн хүүгийн хувийг 2025 онд багтаан хянан үзэх хугацаа тохиож буйтай холбогдуулан Улсын Их Хурлаас “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах арга хэмжээ авах, тус үйл ажиллагааг явуулах Хянан шалгах түр хороог Монгол Улсын Их Хурлаас хуулийн хүрээнд байгуулж ажиллуулах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2025 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулах нь зүйтэй байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөлд дараах агуулгыг тусгана.

- 1.Хянан шалгах түр хороог байгуулах бүрэлдэхүүн, ажиллах хугацаа;
- 2.Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаар;
- 3.Тогтоолыг дагаж мөрдөх хугацаа.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар “Жавхлант”, “Шивээ толгой” ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтуудад үндэслэн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохтой холбогдуулан хяналт шалгалт хийж, хугацаа алдалгүй яаралтай шийдвэрлэхэд Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлнэ.

“Оюутолгой” ХХК-ийн “Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчийн гэрээ”-ний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагаврыг тодорхойлж, энэхүү гэрээнд заасны дагуу 2025 онд багтаан зээлийн хүүг бууруулахад Монгол Улсын Оюутолгой төслөөс хүртэх өгөөж богино хугацаанд бодитоор өсөх боломжтой.

Оюутолгой бүлэг ордын ашиглалттай холбоотой асуудлын ил тод байдалд анхаарч, иргэд олон нийтийг мэдээллээр хангана. Оюутолгой бүлэг ордоос Монголын талын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалтын шинжийг агуулж байх тул уг хуульд заасан судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй болно.

Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Оюутолгой бүлэг ордыг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан байдаг.

Улмаар Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 170 дугаар тогтоолоор Оюутолгойн бүлэг ордын талбайн хил заагийг тогтоосон. Ийнхүү Оюутолгой бүлэг ордын талбайн хил заагийг тогтоосноор Канад Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, тус улсад бүртгэлтэй “Онтрэ ресурс лимитэд” компанийн шууд хөрөнгө оруулалттай, түүний охин компани болох Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад бүртгэлтэй “Онтрэ” ХХК-ийн эзэмшиж буй “Жавхлант”, “Шивээ толгой” ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

“Жавхлант”, “Шивээ толгой”-н ашигт малтмалыг ашиглах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх...” гэж заасан шаардлагыг хангуулах, түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7-д зааснаар “... стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших...” эсхүл түүнийг “ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэж заасан боломжит хувилбаруудаас бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас шийдвэрлэх боломжтой юм.

“Жавхлант”, “Шивээ толгой” стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улс төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохдоо хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын оролцоо, хяналттайгаар, түүнд олон нийтийн санал, хүсэлтийг ил тод, нээлттэй тусган тогтоох замаар “өмнөх алдаа давтагдах”-аас зайлсхийх нь чухал бөгөөд “Оюутолгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлд “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 13.1-д заасны дагуу “Оюутолгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчид болон түүний хамаарал бүхий компаниас авсан зээлийг ойлгох бөгөөд 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Рио Тинто болон түүний хамаарал бүхий компаниас авсан зээлийн нийт үлдэгдэл 11.8 тэрбум ам.доллар (үндсэн зээл: 6.1 тэрбум ам.доллар, хуримтлагдсан хүү: 5.7 тэрбум ам.доллар) байна.

Уг зээлийн хүү нь 3 сарын SOFR дээр нэмэх 6.5 хувь (SOFR+6.5%), бусад зээлийн зардал нэмэгдэн, өнөөдрийн байдлаар ойролцоогоор жилийн 11.1 хувийн хүүтэй байна.

Үүнээс үзэхэд Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн үлдэгдэл үндсэн зээлийн үлдэгдлийн 94 хувьтай тэнцүү байх төлөвтэй байна. Нийлмэл хүүгийн нөлөөгөөр хүүгийн зардал жилээс жилд тасралтгүй өсөх төсөөлөлтэй ба 2028-2037 онд зээлийн хүүд 18.0 тэрбум ам.доллар буюу үндсэн зээлээс 2.8 дахин их хэмжээний хүү төлөхөөр байна.

Түүнчлэн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг Оюутолгойн гуравдагч этгээдээс авсан зээлүүд болох төслийн санхүүжилтийн зээлийн хүүтэй харьцуулахад 1.78-3.5 хувиар өндөр байна.

“Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 11.3(ё)-д 7 жил тутам Санхүүжилтийн хүүгийн хувийн зохистой байдлыг хянан үзэх бөгөөд эдгээр хувийг бүх Тал зөвшөөрснөөр өөрчилж болно гэж заасан байдаг. Үүний дагуу хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулахад Монгол Улсын Оюутолгой төслөөс хүртэх өгөөж богино хугацаанд бодитоор өсөх боломжтой.

Иймд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Оюутолгой төслийн санхүүжилтийн хүүгийн хувийг 2025 онд багтаан хянан үзэх хугацаа тохиож буйтай холбогдуулан, “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр Хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд тусгай шалгалтын хүрээ хязгаарыг 1)“Жавхлант (MV-15225)”, “Шивээ толгой (MV-15226)” ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтуудад үндэслэн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохтой холбогдуулан хяналт шалгалт хийх; 2)“Оюутолгой” ХХК-ийн “Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчийн гэрээ”-ний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагаврыг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах гэж тусгасан болно.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж тус тус заасан.

Оюутолгой төслийн асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь буюу 89 гишүүн энэхүү асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

“Жавхлант”, “Шивээ толгой” стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улсын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 11.3(ё)-д 7 жил тутам Санхүүжилтийн хүүгийн хувийн зохистой хэмжээг авч үзэх заалтыг хэрэгжүүлж, 2025 онд багтаан хүүг бууруулах арга хэмжээ авахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах нэн чухал байна.

Үүний тулд Монгол Улсын Их Хурлаас “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг тэнцвэрт мэдээллээр хангах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2025 оны намрын чуулганы ээлжит хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Хянан шалгах түр хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан “Оюутолгой” бүлэг ордын талбайн хил заагт орших “Жавхлант”, “Шивээ толгой” ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, тэдгээрийн шаардлагыг хангуулах, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний 11.3(ё)-д зааснаар хөрвүүлэх өдрөөс хойш долоон жил тутамд санхүүжилтийн хүүгийн зохистой хувийг хянан үзэх хугацаа 2025 онд тохиож буйтай холбогдуулан, Оюутолгой төслөөс хүртэх Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх”-тэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийн хүрээ, хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/“Жавхлант” (MV-15225), “Шивээ толгой” (MV-15226) ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтуудад үндэслэн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохтой холбогдуулан хяналт шалгалт хийх;

2/“Оюутолгой” ХХК-ийн “Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчийн гэрээ”-ний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагаврыг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

О.Батнайрамдал

.....

Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

.....

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг